## ГАРЧИГ


БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ........ 1
1.1 Төслийн нэр ........ 1
1.2 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл ........ 1
1.3 Төслийн хүчин чадал ........ 2
1.4 Төслийн дэд бүтэц ........ 3
БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ТҮҮНИЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ ........ 5
2.1 Төсөл хэрэгжих талбайн физик газарзүйн нөхцөл ........ 5
2.2 Хөрс, хөрсөн бүрхэвч ........ 5
2.4 Ургамлан нөмрөгийн төлөв байдал ........ 5
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ ........ 7
БҮЛЭГ 4. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ........ 10
БҮЛЭГ5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ........ 11
БҮЛЭГ6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ........ 15
БҮЛЭГ7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗЫН БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ........ 16
БҮЛЭГ 8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ........ 17
БҮЛЭГ 9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ........ 17
БҮЛЭГ10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ. ........ 18
БҮЛЭГ11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ........ 20
БҮЛЭГ12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР ........ 22
БҮЛЭГ13. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭ ........ 24


## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ


Хүснэгт 1 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл ........ 1
Хүснэгт 2 Ил уурхайн ажиллах горим ........ 2
Хүснэгт 3 Уурхайн барилга багууламж ........ 3
Хүснэгт 4 Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд үзүүлэх нөлөөлөх байдлын үнэлгээний нэгдсэн дүгнэлт ........ 9
Хүснэгт 5 БОМТ-ний зардалын задаргаа ........ 10
Хүснэгт 6 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө ........ 11
Хүснэгт 7 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө ........ 15
Хүснэгт 8 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ ........ 16
Хүснэгт 9 Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө ........ 18
Хүснэгт 10 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө ........ 20
Хүснэгт 11 Орчны хяналт шинжилгээ ........ 22
Хүснэгт 12 БОМТ-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ ........ 24
Хүснэгт 13 БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь ........ 25


## ЗУРГИЙН ЖАГСААЛТ


Зураг № I Төслийн байршил ........ 1
Зураг № II Төслийн байр зүйн зураг ........ 2
Зураг № III Уурхйд ашиглагдах тоног төхөөрөмж ........ 3
Зураг № IV FG WILSON брэндын P90-5s маркын дизель генератор ........ 4
Зураг № V Хөрсний хэв шинж ........ 5
Зураг № VI Ургамал хэв шинж ........ 6

# БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

## 1.1 Төслийн нэр

“Үнэгт-Уул”-ийн гөлтгөнийн ордыг ил аргаар ашиглах төсөл

**Төслийн зорилго**: “Үнэгт-Уул”-ийн гөлтгөнийн ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн зорилго нь гөлтгөнө хүдрийг олборлон, боловсруулж эдийн засгийн эргэлтэд оруулахад оршино.

## 1.2 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

**Хүснэгт 1** Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

| | |
|---|---|
| Төсөл хэрэгжүүлэгч | “Арвин хад” ХХК |
| Улсын бүртгэлийн дугаар | 611002101 |
| Регистрийн дугаар | 2683083 |
| Хаяг | Дорноговь, Сайншанд, 4-р баг /Сайншанд, Найрамдал-145-25 тоот/ |
| Утас | 99039576, 99613106 |

***Төслийн байршил:*** Үнэгт-Улын гөлтгөнийн орд нь Дорноговь аймгийн Сайхандулаан сумын нутагт Улаанбаатар хотоос зүүн урагш 450 км, Сайншанд хотоос баруун урагш 95 км, Сайхандулаан сумын төвөөс урд зүгт 40 км-т оршино.

Хүснэгт №. 1 Талбайн солбилцол

| № | Уртраг | Өргөрөг |
|---|---|---|
| 1 | 109° 19' 27.73'' | 44° 17' 22.54'' |
| 2 | 109° 18' 38.73'' | 44° 17' 22.54'' |
| 3 | 109° 18' 38.73'' | 44° 17' 44.54'' |
| 4 | 109° 19' 27.73'' | 44° 17' 44.54'' |



Зураг № I Төслийн байршил




Зураг № II Төслийн байр зүйн зураг

## 1.3 Төслийн хүчин чадал

Үнэгт-Уулын гөлтгөнийн ордыг ашиглалтын 4 жилийн хугацаанд ашиглах бөгөөд энэ хугацаанд 842.6 мян.м$^3$ хөрс хуулж, үйлдвэрлэлийн нөөцөөр 59.2%-ийн дундаж агуулгатай 151.7 мян.тн хүдэр олборлохоор төлөвлөжээ. Жилийн хүчин чадал 43.0 мян.тн хүдэр байна.

### Уурхайн ажиллах горим

Уулын ажил нь техникийн даалгаврын дагуу жилд 8 сар явагдана. Үйлдвэрлэлийн үндсэн процессууд нь тасралтгүй 7 хоног, өдөрт 2 ээлжээр 10 цагаар явагдана.

Хүснэгт 2 Ил уурхайн ажиллах горим

| Үзүүлэлт | Х.нэгж | Хоног |
|---|---|---|
| Календарь хоног | хоног | 208 |
| Жилд ажиллах сар | сар | 8 |
| Ээлжийн үргэлжлэх хугацаа | цаг | 10 |
| Ээлжийн тоо | ээлж | 2 |
| Баяр ёслолын хоног | хоног | 10 |
| Цаг агаарын саатал | хоног | 8 |
| Бэлтгэл ажлын хоног | хоног | 2 |
| **Жилд ажиллах хугацаа** | **хоног** | **188** |

### *Уурхайн ашиглалтын систем*

Ордын геологийн тогтоц, хөрсний чулуулгийн физик-механикийн шинж чанар, олборлолтын арга, механикжуулалтын бүтэц, тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлт зэргийг харгалзан ил аргаар, экскаватор-автосамосвалын хослол бүхий авто тээвэртэй, дотоод овоолготой ашиглалтын системээр үргэлжлүүлэн олборлоно.

**Техник тоног төхөөрөмж**

Ил уурхайд LIEBHERR-R944 маркийн экскаватор 1ш, 25 тн-ын Foton маркийн автосамосвал 3ш, SDLG953 маркийн утгуурт ачигч зэрэг үндсэн тоног төхөөрөмжүүдийг ашиглахаар байна.



Зураг № III Уурхйд ашиглагдах тоног төхөөрөмж

## 1.4 Төслийн дэд бүтэц

**Уурхайн хотхон:** Уурхай, үйлдвэрийн барилга байгууламжид захиргааны байр, ажилчдын болон хоолны байр, агуулахын байр багтах бөгөөд эдгээр нь уурхайн зүүн урд талд байрлана.

Хүснэгт 3 Уурхайн барилга багууламж

| № | Нэр | Хийц, бүрдэл | Тоо, ш |
|---|---|---|---|
| 1 | Сэлбэг, материалын агуулах, 50м2 | Сэндвич | 1 |
| 2 | Харуул хамгаалалтын байр, 5м2 | Сэндвич | 2 |
| 3 | Оффис, 50м2 | Сэндвич | 1 |
| 4 | Амрах байр, 150м2 | Сэндвич | 1 |
| 5 | Гал тогоо, 80м2 | Сэндвич | 1 |
| 6 | Түлшний агуулах, 60м3 | ёмкость | 1 |
| **Дүн** | | | 7 |

Уурхайн барилга байгууламж: Уурхайгаас зүүн хойд зүгт 400 м зайд захиргаа аж ахуйн байр, цайны газар, ажилчдын байрыг барьж байгуулна. Уурхайн тосгоныг байгуулахдаа MNS4934:2000 стандарт, нормативыг баримтлан байгуулсан.

**Усан хангамж:** Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутагт хэрэгжих “Үнэгт”-ийн гөлтгөнийн ордыг ил аргаар ашиглах төслийн усан хангамжийг ордоос 128 км зайд аймгийн төвд байрлах Иргэн Т.Ганбаатарын хувийн гүний худгаас зөөврөөр хангахаар гэрээ байгуулсан байна.

**Уурхайн усан хангамж**

***Ордын гидрогеологи:*** Ерөнхийдөө үнэгтийн район нь гидрогеологийн мужлалаар гадагшаа урсацгүй бүсэд хамаарах бөгөөд уг орд дээр хийсэн хайгуулын ажлын явцад, өрөмдсөн цооногуудад ус агуулсан хурдас илрээгүй бөгөөд цаашдаа уурхайн олборлолтын ажилд гүний усны нөлөөллөх нөлөөгүй байна. Усны үндсэн хэрэглэгч нь уурхайн тосгон, тосгоны унд ахуйн ус болон зам талбай усалгаа байна. Ордын хайгуулын ажлын гидрогеологийн судалгаагаар 30-60 метрийн гүнд газрын доорхи усны түвшин илрээгүй байна. Уурхайн ашиглалт 50 метрийн гүнтэй байна.

**Цахилгаан хангамж:**

90 кВт-ийн чадалтай дизель үүсгүүрээр хангана. Уурхайд хотхоны болон ил уурхайн гэрэлтүүлэг гэсэн цахилгаан хэрэглэгч байна.




Зураг № IV FG WILSON брэндын P90-5s маркын дизель генератор

# БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ТҮҮНИЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

## 2.1 Төсөл хэрэгжих талбайн физик газарзүйн нөхцөл

Үнэгтийн гөлтгөнийн орд нь Монгол орны физик газарзүйн мужлалаар говь хээрийн бүсэд хамаарагдах ба цаг уурын хувьд эрс тэс уур амьсгалтай.

## 2.2 Хөрс, хөрсөн бүрхэвч

Хөрсний бүтэц нь өөрийн тархалт зузаанаараа харилцан адилгүй хүрэн цайвар хүрэн, бор хүрэн, тал нам дор газартаа цайвар шаргал, хужирлаг өндөрлөг газартаа уулын хүрэн хүрэвтэр өнгийн хөрсүүд ялгагдана. Хүрэн цайвар болон бор хүрэн цайвар шаргал хөрс нь аллювиаль-нуурын гаралтай шавар, шавранцраас тогтоно. Хөрсний үеийн зузаан нь 0.05-0.2 м хааяа 30-40 см хүртэл хэлбэлзэнэ.




Зураг № V Хөрсний хэв шинж

## 2.4 Ургамлан нөмрөгийн төлөв байдал

Төслийн талбайн ургамал газарзүйн мужлалаар Евро – азийн хээрийн их муж дагуур, Монголын хээрийн мужид хамаарагддаг. Ургамлын хувьд говийн цөлөрхөг хээрийн монгол өвс, монгол өвс, хазаар өвс, цөлөрхөг хээр голлох боловч монгол өвст-таанат, монгол өвс бударганат хээр, баглуурт буюу бор бударганат цөл нэлээд дэлгэрсэн. Чихэр өвс, заг, хайлааст, зэрэг модлог ургамал, харгана бударгана зэрэг бутлаг ургамал, таана, хөмөл,

монгол өвс, хазаар баглуур, шарилж, ерхөг зэрэг нэг ба олон наст ургамал ургадаг.Эндхийн хүрэн хөрст хуурай хээрт жижиг үетэн - хиагт, хялгана - хазаар өвст, агьт бүлгэмдлүүд зонхилох ба тал хөндийн цайвар хүрэн ба бор хөрст цөлөрхөг хээрээр монгол өвс - хазаар өвст, монгол өвс - таанат, монгол өвс - бударганат, өдлөг хялганат, өдлөг хялгана - хазаар өвст, өдлөг хялгана - таанат, өдлөг хялгана - боролзойт эвшлүүд тохиолдоно.




Зураг № VI Ургамал хэв шинж

## БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

**Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл:** Хөрс хуулах, хүдэр олборлох үед тоос, шороо ихээр үүсгэнэ. Уурхайн малталтууд болон овоолгын дээд талбайгаас салхинд хийсэх тоос, шороо, уурхайд ажиллах машин техникүүдийн шингэн түлшний шаталтаас ялгарах утаа, хөө тортог, хорт хийнүүд, ажилчидын суурингаас гарах хатуу шингэн хог хаягдлын бохирдол, өрөмдлөг, тэсэлгээний ажил хийх үед гарах тоос, шороо, хөрс хуулах, түрэх, тээвэрлэх, элс угаах зэрэг бүхий л ажиллагаа тасралтгүй явагдах тул бульдозер, экскаватор, автомашин, бусад төхөөрөмжийн дуу чимээ болон хорт хий утаа гарах, тоос шороо дэгдэх зэргээр агаар орчныг бохирдуулж, хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлнө.

**Газрын гадарга болон хэвлийд үзүүлэх нөлөөлөл:** Төслийн зүгээс газрын гадарга болон хэвлийд үзүүлэх гол нөлөөлөл нь барилга угсралтын ажил болон төслийн үйл ажиллагаатай холбоотой уурхайн карьер, овоолго болон тээврийн хөдөлгөөн зэрэг эх үүсвэрүүдээс үүснэ.

**Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөлөл :** Төслийн хүрээнд төлөвлөж буй ил уурхайн барилга байгууламжид хөрс удаан хугацаанд дарагдана. Түүнчлэн дэд бүтцийн барилга, байгууламжийн ойр орчимд машин техник, хүний үйл ажиллагаагаар элэгдэл, эвдрэл, бохирдол их үүснэ. Уурхайн уйл ажиллагааны явцад нүүрс-ус буюу шатахуун, түүнтэй төстэй бутээгдэхүүн, мөн химийн бодисын асгаралт, шүүрэлтээс хөрс бохирдох боломжтой. Шатахуун болон химийн бодисын агуулах, сав, машин техникийн тээвэрлэлт ачаалалтын үед асгаралт үүсэж хөрсний боломжит бохирдол ихэнхдээ үүсдэг.

**Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөөлөл:** Хөрс хуулалт болон барилга угсралтын явцад тоосжилт дарахад цэвэр усны нөөц хомсдох, Уулын малталтын үед хөрсний болон гүний усыг зайлуулж усны неөц хомсдох, Барилга угсралтын ажлын явцад барилгын материал хур тунадас болон үерийн усаар угаагдан барилгын материалд агуулагдах бодисууд хөрсөнд нэвчих, улмаар хөрсний бага гүний усыг бохирдуулах, Баяжуулах үйл ажиллагаа явуулахад химийн бодис алдагдахаас үүдэн хөрсний болон гүний усыг бохирдуулах, Уулын ажлын болон ахуйн бохир ус хадгалах савыг соруулах үед асгарч газрын хэвлий болон хөрсийг бохирдуулхаас үүдэн хөрсний усыг бохирдуулах, Уулын ажлын болон ахуйн бохир ус хадгалах сав хүчтэй аадар бороо болон үерийн усаар дүүрч хальхаас үүдэн хөрсөнд нэвчиж хөрсний ус болон бага гүний усыг борхирдуулах эрсдэлтэй байна.

**Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл:** Төслийн талбайд ил уурхай байгуулах, шимт хөрсний болон хаягдал чулуулгийн овоолго бий болгох, уурхайн зам, дэд бүтцүүдийн барилгын ажил хийгдэх зэрэгтэй холбоотойгоор хөрс хуулалт явагдах ба эдгээр үйл ажиллагаа нь ургамлан нөмрөгт шууд болон шууд бус нөлөөллийг үзүүлнэ. Мөн уурхайн

байнгын үйл ажиллагаа ургамлан нөмрөгт дам нөлөөлөл богино ба урт хугацаанд үзүүлсээр байх юм.

**Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл:** Барилга угсралтын үед ажиллах хүнд даацын автомашин, техник хэрэгслүүдийн дуу чимээнээс амьтад үргэн дайжих, Ургамлан нөмрөгт төслийн үйл ажиллагааны явцад ялгарсан, асгарсан бохирдуулагч материалууд хуримтлагдсанаас өвсөн тэжээлтэн амьтад хордох, Тоосжилтын улмаас ургамал ургах чадвараа алдан ургамлын арви багассанаас өвсөн тэжээлтнүүд хоол тэжээлийн хомсдолд орох, Төслийн ажилчид санаандгүй болон санаатайгаар амьтадыг устгаж болзошгүй, Шувууд утаанд хордох, цахилгаан хүчдэлд цохиулах зэрэг багтана.

**Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл:** Төслийг хэрэгжүүлэхд ажиллах хүчийг төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн оршин суугчдаас авч ажиллуулах нь оршин суугчдын амжиргаа, нийгэм эдийн засгийн хөгжилд эерэг нөлөө үзүүлэхээр байна.




ЗУРАГ №. 1 ТӨСЛӨӨС ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ

- Дараах зурагт нөлөөлөл буурах функц ашиглан нөлөөллийн эрчим, орон зай, цаг хугацааны тархалтыг зураглалаа.
- Нөлөөлөл буурах зай болон нөлөөллийн эрчим нь төсөл хэрэгжих талбайгаас 300м радиуст нөлөөллийн эрчим хүчтэй, 500м радиуст нөлөөллийн эрчим дунд 800м-т радиуст аажмаар буурч байна.

Хүснэгт 4 Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд үзүүлэх нөлөөлөх байдлын үнэлгээний нэгдсэн дүгнэлт

| № | Төслийн үйл ажиллагаа | Нөлөөллийн үнэлгээ | | | | Нийт |
|---|---|---|---|---|---|---|
| | | Бага | Дунд | Их | Маш их | |
| 1 | Агаарын чанар | 3 | 3 | 5 | 2 | 13 |
| 2 | Амьтны аймаг | 17 | 7 | | | 24 |
| 3 | Гадаргын болон газрын доорхи ус | 8 | 2 | 7 | | 17 |
| 4 | Газрын гадарга болон хэвлий | 3 | 2 | 3 | 11 | 19 |
| 5 | Ургамлан нөмрөг | 8 | 13 | 1 | | 22 |
| 6 | Хөрсөн бүрхэвч | 2 | 5 | 10 | 1 | 18 |
| | Нийт /тоогоор/ | 41 | 32 | 26 | 14 | 113 |
| | Нийт /хувиар / | 36% | 28% | 23% | 12% | 100% |

Үүнээс үзэхэд төслөөс байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл нь нөлөөллийн хувьд ДУНД зэрэг байна. Иймд төслийн барилга угсралт болон элс олборлох үйл ажиллагааны турш орчны хяналт шинжилгээг тогтмол хийж, аливаа үүсэх эрсдэл нөлөөллөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, хөтөлбөрүүдийг авч хэрэгжүүлэн, үндэсний болон олон улсын стандартын дагуу нөхөн сэргээлт, байгаль орчныг хамгаалах хөтөлбөрүүдийг уурхайн ТЭЗҮ болон энэхүү БОННҮ-ний тайлангийн “Байгалийн аюул, уурхайн үйл ажиллагааны явцад гарч болзошгүй гэнэтийн ослын үнэлгээ”, “Уурхайн хаалт, нөхөн сэргээлт, экологи эдийн засгийн хохирлын үнэлгээ” болон “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө” зэрэг бүлэгт заасан хувиар чиглэлийн дагуу уурхайн жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусган зохих арга хэмжээг авч хэрэгжүүлж байх нь зүйтэй.

# БҮЛЭГ 4. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн хэрэгжилтийн явцад барилга байгууламжийн бүтээн байгуулалт, уурхайн олборлолтын үйл ажиллагааны улмаас хамгийн ихээр эвдрэлд орж сөрөг нөлөөлөлд өртөх бүрэлдэхүүн нь хөрсөн бүрхэвч юм. Сөрөг нөлөөллийн цар хүрээ багаас дунд зэрэг ба урьдчилан сэргийлэх болон бүтээн байгуулалтын дараа болон олборлолт дууссан хэсэгт нөхөн сэргээх талаар төлөвлөсөн арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх тохиолдолд нөлөөллийн эрчим эрс буурах боломжтой.

Төслийн ерөнхий үнэлгээний нөхцөлд заагдсаны дагуу байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар жил бүрийн төлөвлөгөөг БОАЖЯ-ны Сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын дагуу тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг энэхүү тайлангийн 2 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг (БОМТ) үндэслэн боловсруулж БОАЖЯ-д ирүүлэн батлуулах ба батлагдсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн ажлын тайланг холбогдох газруудад хүргүүлж байх шаардлагатай. Үүнээс гадна тус Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ), түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь”-ийн дагуу оролцогч сонирхогч талуудыг холбогдох мэдээллээр ханган ажиллах үүргийг төсөл хэрэгжүүлэгч хүлээнэ.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинижлгээний хөтөлбөр, тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан бөгөөд төслийн 2020 оны менежментийн төлөвлөгөөний ажилд нийт **5.5 сая.төг** зарцуулахаар төсөвлөв.

Хүснэгт 5 БОМТ-ний зардалын задаргаа

| № | Байгаль орчны менежментийн төлөвлөгөө | Нийт зардал /мян.төг/ |
|---|---|---|
| 1 | Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээний төлөвлөгөө | 1,0 |
| 2 | Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө | 1.0 |
| 3 | Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | 1.0 |
| 4 | Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө | - |
| 5 | Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | - |
| 6 | Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө | 1.0 |
| 7 | Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө | 0.5 |
| 8 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | 0.5 |
| **9** | Удирдлага зохион байгуулалтын талаар авах арга хэмжээ | 0.5 |
| 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал | | **5.5** |

## БҮЛЭГ5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 6 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

| № | Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Нэгжийн зардал мян.төг | Тоо хэмжээ | Нийт зардал, мян.төг | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж 2024 он | Баримтлах эрхзүйн баримт, стандарт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | | **Агаарын чанар** | | | | | | | |
| | Уурхайн олборлолт болон тээврийн Хэрэгслүүдийн үйл ажиллагааны улмаас гарч болох тоосжилтын эх үүсвэрүүд:<br>-Уурхайн олборлолтын үеийн хөрс хуулалт, олборлолт, овоолго хийх газар шорооны ажил,<br>-Уурхайн үйл ажиллагаанд ашиглаж буй тээврийн хөдөлгөөн, Тээвэрлэлтэнд явж буй | Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, хаалга цонхны чигжээс, хамгаалалтын үзлэгийг хийх | Үйл ажиллагааны турш | - | | - | Ү.А-ны зардлаар | + | Агаарын тухай хууль<br>Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS5885:2008<br>MNS(ISO)13688:2000<br>MNS3306:1991<br>MNS5620:2006<br>MNS5623:2006<br>MNS5388:2004<br>MNS5389:2004<br>Бензинхөдөлгүүрт MNS 5013:2003<br>Дизель хөдөлгүүрт MNS 5014:2003 |
| | | Хүнд машин механизмын хөдөлгүүрийн тохиргоо, үйлчилгээг тогтмол байлгах, техникийн оношлогоонд машин техникийг хамруулна. | Үйл ажиллагааны турш | - | | - | | + | |
| | | Уурхайн ажиллагсдад тоосноос хамгаалах хушуувч, амны маск, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр хангах | Үйл ажиллагааны турш | - | | - | - | + | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | машинуудаас ялгарах хорт бодисуудаар орчны агаар бохирдох<br>-Ажиллагсад болон нутгийн иргэдийн эрүүл мэндэд нөлөөлөх | | | | | | | | |
| 2 | **Хөрсөн бүрхэвч** | | | | | | | | |
| | Ордын ашиглалтын явцад хөрсний бүтэц найрлагад өөрчлөлт орох, хог хаягдал, тоосжилтоос бохирдол үүсгэх, хүнд даацын машин механизмууд олон салаа зам гаргаж хөрс болон ургамлыг гэмтээх. | Шимт хөрсийг хадгалах | Үйл ажиллагааны турш | - | | - | Ү.А-ны зардлаар | + | “Газрын тухай” хууль<br>MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга |
| | | Уурхайн ойр орчим орц гарцыг тэмдэгжүүлэх | Үйл ажиллагааны турш | - | | - | | + | |
| | Замыг засаж сайжруулах | Тогтсон маршрутаар явах. Шинэ зам гаргахгүй байх. | | | | | | | |
| | | Усанд идэгдсэн болон хонхойсон зам харгуйг тэгшлэх | | | | | | | |

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН УЛААНБАДРАХ СУМЫН НУТАГТ ОРШИХ "ҮНЭГТ УУЛЫН" ГӨЛТГӨНИЙ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | **Усны нөөц, усны чанарт** | | | | | | | | |
| | Гүний усыг ашигласнаар усны нөөц хомсдох, усны бохирдол, шатах тослох материалыг алдсанаар газрын доорх ус бохирдох, газар доорх устай холбогдон ургадаг ургамалжилтанд сөргөөр нөлөөлж болзошгүй. | Ажилчдын аюулгүй ажиллагааны дүрэмд усыг ариг гамтай хэрэглэх, хамгаалах тухай тусгаж өгөх | Ажилчдад | - | | - | Осол эрсдэлийн менежментийн зардалд | + | |
| | | Ажилчдын унд ахуйн усанд ашиглаж байгаа гүний худгаас дээж авч шинжилгээ хийлгэж, усны найрлагыг тодорхойлуулж, ундны усны стандартад нийцэж буйг хянаж байх | Ажилчдын байрны хүрээнд | - | | - | Орчны хяналт шинжилгээний зардалд | Сард 1 удаа | |
| 4 | **Амьтны аймаг, ургамлан нөмрөг** | | | | | | | | |
| | Үйл ажиллагаа явуулсантай амьтны нөөц хомсдох, ухсан нүх шуудуунд мал амьтан унахаас сэргийлэх | Хог хаягдалыг ил задгай хаяж хүнд ойромсог амьдардаг, хог хаягдлын индикатор амьтад үржих, хордох нөхцөл бүрдүүлэхгүй байх | Уурхайн хүрээнд | - | | - | 240.0 | + | |
| | Хог хаягдлыг ангилан ялгах хогын сав байршуулах | | Уурхайн хог хаягдлын хүрээнд | - | | - | Хог хаягдлын менежментийн зардалд | + | Хог хаягдлын тухай хууль 2017 он |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | **Дуу чимээ** | | | | | | | | |
| | Нутгийн иргэдийн амгалан тайван байдлыг алдагдуулах | Олборлолтын ажлыг өдрийн цагаар гүйцэтгэх | | - | | - | - | + | |
| **Нийгмийн хариуцлагын хүрээнд** | | | | | | | | | |
| | Нутгийн иргэд болон сум засаг захиргаатай хамтран ажиллах | Улаанбадрах суманд хандив тусламж үзүүлэх | Уурхайн хүрээнд | - | | - | - | + | |
| | | Хүүхдүүдийн боловсролыг дэмжих Монгол бичгийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор ном товхимолоор хангах | Уурхайн хүрээнд | - | | - | - | + | |
| | **Нийт** | | **1.0 сая.төг** | | | | | | |

## БҮЛЭГ6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 7 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

| № | **Нөхөн сэргээлтийн зорилт** | Нөхөн сэргээлтийн арга хэмжээ | Арга хэмжээний цар хэмжээ | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн зардал, төг | Нийт зардал мян,төг | Хэрэгжүүлэх хугцаа ба давтамж | Баримтлах эрх зүй баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Нөхөн сэргээлтийн ажлын техникийн үе шатанд орд газрыг ашиглаж дууссаны дараа болон ашиглалтын явцад уурхайн чөлөөлөгдсөн орон зайг цаашид аж ахуйн үйл ажиллагаанд үргэлжлүүлэн ашиглах зорилгоор нөхөн сэргээхэд техникийн нөхөн сэргээлтийн гол зорилт юм. | 0.111 га талбайд зам далан барих. Шороон далан зам 300м, хамгаалалтын далан 150м | Үйл ажиллагааны дуусмагц | га | _ | | Үйл ажиллагааны зардлаар | _ | “Байгаль орчныг хамгаалах тухай” “Ашигт малтмалын тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” MNS5915:2008MNS5916:2008 MNS5917:2008 |
| | | 0.38 га талбайд дотоод овоолгын техникийн нөхөн сэргээлт хийх | | га | | | | | |
| | | 0.0025 га талбайд шимт хөрсний нөөц овоолго байрлуулах | | га | _ | | Үйл ажиллагааны зардлаар | _ | |
| Нийт 1.0 сая.төг | | | | | | | | | |

## БҮЛЭГ7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗЫН БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 8 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ

| № | Дүйцүүлэн хамгаалах зорилт | Хамгаалах арга хэмжээ | Хамрах хүрээ | Хэрэгжүүлэх давтамж | Хэрэгжүүлэх хугацаа (он), сая.төг | Нийт зардал /сая.төг/ | Баримтлах эрхзүйнбаримт бичиг,стандарт аргачлал |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | **2024** | | |
| | **ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ** | | | | | | |
| 1 | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд | 0.1 га талбайд 150 ширхэг мод тарих. Мөн хашаажуулах,модны үрсэлгээ авч бэлтгэх,ургуулах | Төслийн талбайд | | + | | |
| | **Нийт дүн, мян.төг** | | **1.0 сая.төг** | | | | |

## БҮЛЭГ 8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

2024 онд тухайн төслийн уурхайлалтын болон эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд иргэд, оршин суугчид, айл өрх байхгүй байна. Иймд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө тусгагдаагүй болно.

## БҮЛЭГ 9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжих бүс нутаг, түүний орчимд хийсэн археологийн судалгаа, түүх соёлын өвийн судалгааны дүн, түүх, соёлын өв дурсгалуудын талаарх нутгийн иргэд, холбогдох байгууллагын мэдээлэлд үндэслэн түүх, соёлын өв дурсгалуудыг хамгаалах төлөвлөгөө боловсруулна. Уурхайн ашиглалтын үйл явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол уурхайн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлыг зохион байгуулах болно.

## БҮЛЭГ10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.

Хүснэгт 9 Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө

| Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар хэмжээ | Тоо хэмжээ | Нэгжийн зардал | Нийт зардал (мян\төг) | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|
| Цаг агаарын үзэгдэл, ажилчдын хариуцлагагүй байдлаас шалтгаалан осол гарах | Байгалийн аюул гамшигаас урьдчилан сэргийлэх, арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах | Нийт ажиллах хугацаанд уурхайн бүх ажилчдад | - | Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгагдсан | | 2024 он | Гамшгаас хамгаалах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль |
| | Осол эрсдэл үүссэн үед устгах арга хэмжээний төлөвлөгөөтэй байх | Төслийн бүхий л үед хэрэгжүүлэх ХХАА-ны гарын авлагатай болох | - | Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгагдсан | | 2024 он | |
| | Болзошгүй аюул ослын үед ашиглах багаж хэрэгсэл холбооны хэрэгсэлтэй болох | Ус, элс, шороо, хүрз цэвэрлэгээний бодис, холбооны хэрэгсэл гэх мэт | 2 | 200 | | 2024 он | |
| Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх, байгалийн гамшиг | Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах, Машин техникийн үйлчилгээ засварыг тусгай бэлтгэсэн талбайд явуулж хэвших | | - | 220 | | 2024 он | |
| | Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах | | - | | | | |
| | Цахилгаан тоног төхөөрөмж болон монтажид мэргэжлийн ажилтнаар үзлэг хийлгэж | | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | засварлуулах,газардуулгын ажиллагааг шалгах,засварлуулах | | | | |
| | Галын аюулгүй ажиллагааны пост ,гал унтраах багаж хэрэгсэл бэлтгэн,таниулах анхааруулах самбар ,галын хорны бүрэн бүтэн байдал хэрэглээ бэлэн байдалд хяналт тавих | | | | |
| | Ажилд гарахын өмнө өдөр бүр аюулгүй ажиллагааны зааварчлагаа өгөх,шаардлагтай бол нэмэлт зааварчлагааг ажлын явцад өгөх | | | | |
| **Нийт зардал (мян.төг)** | | | **500.0** | | |

## БҮЛЭГ11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 10 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

| Хог хаягдлын ангилал | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ | Хэмжих нэгж | Нэгжийн зардал, төг | Тоо хэмжээ | Нийт зардал, мян.төг | Төсөл хэрэгжүүлэх хугацаа 2024 он | Баримтлах эрх зүйн баримт, стандарт |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдол | Шингэн хог хаягдалыг ажилчдын байрны ойролцоо муу усны нүх бие засах цэгт хаяна. | Үйл ажиллагааны турш | | | | 100.00 | + | Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага MNS 5344:2011 |
| Ахуйн хатуу хог хаягдлаар газрын гадарга бохирдох; | Техникийн хаягдал тос маслыг саванд тосож авч Сайншандад хаягдал боловсруулах цэгт тушааж үр дүнг тайланд тусгаж өгнө | Үйл ажиллагааны турш | | | | 100.00 | + | Хог хаягдлын тухай хууль |
| Хог хаягдал, ШТМ-ын хаягдал хурын усаар дамжин гүний усыг бохирдуулах | Техникийн болон бусад хатуу хог хаягдал төмөр, дугуй, сольсон аккумлятор зэргийг хоёрдогч түүхий эд авах цэгт хүргэж тушаана. | Төслийн талбай дахь худгийн усанд | | | | ОХШХ-т тусгасан аар | + | MNS 3936:1986 Ундны ус болон үйлдвэрийн ус-Тухайн талбарт нь шинжилгээ хийх<br>MNS 0900:2005 Ундны ус. Эрүүл ахуйн |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ |
| Нийт | | 500.0 мян.төг | | | | | | |

## БҮЛЭГ12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүснэгт 11 Орчны хяналт шинжилгээ

| № | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд | Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл | Хяналт шинжилгээ хийх байршил | Хугацаа ба давтамж 2024 он | Давтамжийн тоо | Нэгжийн зардал (мян.төг) | Нийт зардал (мян.төг) | Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Хөрсний бохирдол** | | | | | | | | |
| 1 | Хөрсний морфологи бичиглэл, pH, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент, хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд | Хөрс элэгдэл эвдрэлд орох, үржил шимээ алдах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх | Төслийн талбайд 2 цэг сонгох /Уурхайн кемп орчим, уурхайн ухаш/ | Хагас жил тутамд | Жилд 2 удаа | 15.0 | 2 цэгт x 2 дээж x жилд 2 удаа x 1жил /15.0/ НИЙТ 120,0 /Хөрсний химийн шинжилгээ 1 дээж - 15.0 төг, | MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойолох арга,<br>MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга,<br>MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга,<br>MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга<br>MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага<br>MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга<br>MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга<br>MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ |
| | Хүнд металлын агууламж | Түлш, тосолгооны материал хог хаягдлаар хөрс бохирдох | 2 цэгт /Засварын цех, ШТС/ | Хагас жил тутамд | Жилд 2 удаа | 20.0 | 2 цэгт x 2 дээж x жилд 2 удаа x 1 жил x 20,0 Нийт 160,0 хүнд металлын шинжилгээ | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 1 дээж-20.0 төг/ | |
| **Усны хяналт шинжилгээ** | | | | | | | | |
| 2 | Усны чанар pH, ууссан нийт давс (жингийн аргаар), усны ерөнхий болон хүнд металлын шинжилгээ | Төслийн талбай орчим | Унд ахуйн усыг хангаж буй уснаас | 2024 он | Жилд 2 удаа | 40.0 | 40.0*2 удаа х 1жил НИЙТ 80.0 | MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж<br>MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага<br>MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж<br>MNS 13.060.50 Усны чанарын стандарт<br>MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт |
| 3 | Усны түвшин усны ундарга нөөц | Ус ашиглалтаас, зарцуулалтаас газар доорх усны горим өөрчлөгдөх | Гүний худгийн ус, Гол | 2024 он | | | | |
| **ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН 2024 ОНЫ ЗАРДЛЫН ДҮН** | | | | | | | **500.0** | |

## БҮЛЭГ13. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭ

Хүснэгт 12 БОМТ-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний цар хэмжээ | Нэгжийн өртөг мян.төг | Зардал мян.төг | Хугацаа 2024 он |
|---|---|---|---|---|---|
| 1 | Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх шинэчлэн засварлах | Уурхайн хэмжээнд | Дотоод зохион байгуулалтаар | | 2024 он |
| 2 | Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар удаа сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах. | Уурхайн хэмжээнд | Удирдлагын түвшинд | | 2024 он |
| 4 | Байгаль хамгаалах талаар хийсэн ажлыг жил бүрийн тайланг БОАЖЯ болон сумын ЗДТГ-т хүргэн өгч байх | Уурхайн хэмжээнд | Дотоод зохион байгуулалтаар | | Жил бүрийн 12 сард |
| 5 | Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөл сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө | Уурхайн хэмжээнд | Дотоод төлөвлөлтөөр | | 2024 он |
| 6 | Яаралтай анхны тусламжид шаардлагатай эм тариа, багаж хэрэгслийг бэлтгэж, шаардлагатай газруудад байрлуулах | Уурхайн хэмжээнд | - | 250.00 | 2024 он |
| 7 | Хөдөлмөр хамгаалал эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах сургалт зохион байгуулах | Уурхайн хэмжээнд | Ослын сургалттай хамтран хэрэгжүүлэх | | 3-р улирал |
| 8 | ХАБЭА-н сургалтад нийт ажилчдыг хамруулах | Уурхайн хэмжээнд | Дотоод зохион байгуулалтаар | | Улирал бүр |
| 9 | Ажиллагсдыг нормын хувцас,хамгаалах хэрэгсэлээр хангах | Уурхайн хэмжээнд | Дотоод зохион байгуулалтаар | | Жил бүр |
| 10 | Яаралтай анхны тусламжид шаардлагатай эм тариа, багаж хэрэгсэлд зарцуулах зардал | Уурхайн хэмжээнд | 50.0 | 100.0 | Жилд 2 удаа |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Хүнд нөхцөлд ажиллагсдад хор саармагжуулах ундаа,сүү,вакус зэргээр хангах | Уурхайн хэмжээнд | Дотоод зохион байгуулалтаар | Улирал бүр | Уурхайн хэмжээнд |
| | Нарийн мэргэжлий эмчийн үзлэгт нийт ажилчдыг хамруулах Орон нутгийн эмнэлэгт | Уурхайн хэмжээнд | Дотоод зохион байгуулалтаар | Жил бүр | Уурхайн хэмжээнд |
| | Уурхайн карьер овоолго,ачиж буулгах зам талбайн анхааруулах тэмдэг тэмдэглэгээг сайжруулж шаардлагтай хэсэгт нэмж байрлуулах | Уурхайн хэмжээнд | Дотоод зохион байгуулалтаар | Улирал бүр | Уурхайн хэмжээнд |
| | Байгаль орчны аудитын тайланг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэх | Уурхайн хэмжээнд | Дотоод зохион байгуулалтаар | Жил бүр | Уурхайн хэмжээнд |
| | Газрын төлөв байдал чанарын хянан баталгаат ажлын тайланг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэх | Уурхайн хэмжээнд | Дотоод зохион байгуулалтаар | Улирал бүр | Уурхайн хэмжээнд |
| **Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт зардал** | | | | 500.0 мян.төг | |

## БҮЛЭГ14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ

**Хүснэгт 13** БОМТ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ

| БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх оршин суугчид, оролцогч талууд | Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр | Мэдээний агуулга | Хугацааны тов | Тайлагнах зардал, төг | Зохион байгуулах албан тушаалтан | Зохион байгуулах газар |
|---|---|---|---|---|---|---|
| БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг төсөл хэрэгжиж буй аймгийн сумдын ажлын хэсэгт танилцуулах | БОМТ-ний биелэлтийн тайлан боловсруулж сумын засаг захиргаанд хүргүүлнэ | Тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх | 2024.11.01-нд хүргүүлэх | - | Байгаль орчны мэргэжилтэн | |
| **Нийт** | | **500.0 мян.төг** | | | | |